

ХЭСЭГ С: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

С1 – ТАНИЛЦУУЛГА

АГУУЛГА

1. УДИРТГАЛ	2
1.1 НӨЛӨӨЛЛИЙН АНГИЛАЛ БОЛОН ЗЭРЭГЛЭЛ	2
1.2 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА ХЯНАЛТ	3
1.3 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ	3

1. УДИРТГАЛ

БОННБУ– ний энэхүү хэсэгт Оюу Толгой Төслийн зүгээс үзүүлж болзошгүй байгаль орчны болон нийгмийн нөлөөллүүдийн үнэлгээний талаар өгүүлэх болно. Уг үнэлгээг барилгын ажлаас ашиглалт болон хаалт/татан буулгах хүртэлх Төслийн үе шат тус бүрийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчинд болон нийгмийн нөлөөллүүдэд хийсэн болно.

Бүлэг тус бүрт дараахи мэдээллүүдийг багтаасан:

- Гол асуудлууд болон үүсэх нөлөөллийн тухай танилцуулга;
- Үнэлгээний орон зайн, техникийн болон цаг хугацааны хамрах хүрээний тодорхойлолт;
- Төслийн үргэлжлэх бүхий л хугацааны туршид үүсэх нөлөөллийн тодорхойлолт болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ;
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсны дараахи үлдэгдэл нөлөөллийн үнэлгээ; мөн
- Үнэлгээний товч хураангуйг хүснэгт хэлбэрээр үзүүлсэн байдал.

1.1 НӨЛӨӨЛЛИЙН АНГИЛАЛ БОЛОН ЗЭРЭГЛЭЛ

Нөлөөллийн үнэлгээг нэгэн ижил арга барилаар хийх зорилгоор нөлөөллийн зэрэглэлийг тодорхойлоход дараахи шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэсэн.

- **Үргэлжлэх хугацаа:** Богино, дунд болон урт хугацааны;
- **Хамрах хүрээ:** Зөвхөн орон нутгийн шинж чанартай, орон нутгийн болон хязгаарлагдмал, өргөн хүрээний; мөн
- **Магадлал:** Магадлал маш багатай, магадлал багатай, магадлалтай, гарцаагүй.

Нөлөөллийг эерэг ба сөрөг гэж ангилсан бөгөөд сөрөг нөлөөллүүдийг дараахи таван ангилалын аль нэгэнд хамруулсан:

- **Эерэг:** Эх үүсвэр болон шууд нөлөөлөлд өртөгчдөд эерэгээр нөлөөлөх буюу давуу талтай;
- **Нөлөөгүй (Сөрөг):** Гол төлөв богино хугацааны /эсвэл зөвхөн орон нутгийн шинж чанартай ба/ эсвэл магадлал маш багатай нөлөөлөл;
- **Бага (Сөрөг):** Гол төлөв богино хугацааны нөлөөллөөс дунд хугацааны /эсвэл орон нутгийн шинж чанартай/ эсвэл магадлал багатай нөлөөлөл;
- **Дунд зэрэг (Сөрөг):** Гол төлөв дунд хугацааны /эсвэл хязгаарлагдмал ба/ эсвэл магадлалтай; мөн
- **Их (Сөрөг):** Урт хугацааны /эсвэл өргөн хүрээний/ эсвэл гарцаагүй. Түүнээс гадна сөрөг болон маш их хэмжээтэй гэдгээрээ Төслийн стандартад үл нийцэх нөлөөллүүд бас багтана.

Нөлөөллийн үнэлгээний зэрэглэлийг тогтоох ажил нь харьцангуй субъектив ойлголт бөгөөд БОННБУ– г гүйцэтгэж буй багийн янз бүрийн салбарт төстөй үнэлгээ хийж байсан өргөн хүрээний туршлагад үндэслэдэг юм.

Нөлөөллийн үнэлгээг стандарт шалгуурын дагуу нэгтгэн дүгнэх зорилгоор Бүлэг тус бүрийн төгсгөлд хүснэгтлэн оруулсан. Нөлөөллийг боломжтой тохиолдолд тоон утгаар илэрхийлэх бөгөөд дунд зэрэг болон их гэж үнэлэгдсэн сөрөг нөлөөллүүдийг онцлон авч үзэх бололцоотой юм.

1.2 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА ХЯНАЛТ

Олон улсын аж үйлдвэрийн тэргүүн туршлагад нийцсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээг¹ Төслийн төлөвлөлтөд тусган оруулж өгсөн бөгөөд барилгын, үйл ажиллагааны болон хаалтын үе шатуудын туршид хэрэгжүүлэх болно. Бууруулах арга хэмжээг нөлөөллийн бүх түвшинд хэрэгжүүлэх ажлын хамтаар тодорхойлж өгсөн. Эдгээр арга хэмжээг төслийн барилгын, үйл ажиллагааны болон хаалтын зэрэг бүх үе шатуудад тодорхойлсон. Нөлөөллийг бууруулах болон менежментийн арга хэмжээнээс гадна төслийн хэрэгжих хугацааны туршид үлдэх нөлөөлөлд авах арга хэмжээг мөн БОННБҮ– ний D хэсэг буюу Менежментийн төлөвлгөөнүүдэд оруулж өгсөн. Нөлөөллийг бууруулахад дараахи арга хэмжээг даган мөрдсөн:

- Нөлөөллөөс зайлсхийх боломжуудыг анхан шатны төлөвлөлтөд тусгах замаар нөлөөллийг арилгах;
- Бусад боломжит хувилбаруудыг үнэлэн, боломжтой тохиолдолд хамгийн бага нөлөөлөл үзүүлэх хувилбарыг сонгон авах;
- Үлдэц нөлөөллийг бууруулах зорилгоор анхан шатны төлөвлөлтөд өөрчлөлт оруулах;
- Үлдэц нөлөөллийн бууруулах зорилгоор менежментийн арга хэмжээг авах эсвэл биологийн төрөл зүйлийн нөөцөд алдагдал учруулахгүй байх нөхцлийг бүрдүүлэх үүднээс тэнцвэржүүлэх хөтөлбөр боловсруулах; мөн
- Дээрхи арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний дараагаар үлдэх нөлөөллийг шийдвэрлэх зорилгоор шударгаар нөхөн төлбөр олгох арга хэмжээг тодорхойлох.

1.3 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ

Эдгээр нөлөөлийн үнэлгээнүүд биофизикийн болон хүний амьдрах орчныг хамарна. Үүсэх нөлөөлөлүүд нь шууд болон шууд бус эсэхийг тодорхойлох зорилгоор байгаль орчны олон талт асуудлууд тэдгээрийн харилцан холбоог бүлэг бүрт тодотгож үнэлгээг хийсэн.

Энэхүү хэсэг нь дараахи бүлгүүдээс бүрдэнэ:

- C1: Танилцуулга (энэхүү бүлэг)
- C2: Уур амьсгал болон агаарын чанар
- C3: Дуу чимээ ба чичиргээ
- C4: Топографи, геологи болон хөрс
- C5: Усны нөөц
- C6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдал
- C7: Эдийн засгийн нөлөөлөл
- C8: Хүн ам болон хүн амын төвлөрөл
- C9: Хөдөлмөр эрхлэлт
- C10: Газар ашиглалт болон нүүлгэн шилжүүлэлт
- C11: Соёлын өв
- C12: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал
- C13: Хуримтлагдах нөлөөлөл.

¹ Дэлхий нийтийн хэмжээнд ижил төрлийн салбарт буюу ижил нөхцөл байдалд ажилладаг мэргэжлийн ур чадвартай, туршлагатай мэргэжилтүүдийн мэргэжлийн ур чадвар, хичээл зүтгэл, алсын хараатай, хянамгай гярхай байдал хэмээн тодорхойлсон (ОУСК ГС-2)

Орчуулгын үнэн зөв баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.